

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/73/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: khurelbaatart@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан	13
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт.....	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.3 Албан шаардлага.....	19
4.4 Зөвлөмж	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/147
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА С.ПҮРЭВЖАВ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2022 ОН/ALBAN BICRIG 19000/68

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	71,558,764.00	28,593,194.00
33	АВЛАГА	41,374,500.00	1,430,000.00
335	Бусад авлага	41,374,500.00	1,430,000.00
3351	Байгууллагаас авах авлага	41,374,500.00	1,430,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	30,184,264.00	27,163,194.00
354	Хангамжийн материал	21,644,264.00	18,623,194.00
35410	Бичиг хэргийн материал	1,795,900.00	2,344,900.00
35420	Аж ахуйн материал	10,048,364.00	11,023,294.00
35430	Сэлбэг хэрэгсэл	880,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	8,300,000.00	2,800,000.00
35470	Бусад хангамжийн материал	620,000.00	2,455,000.00
35600	Мал амьтад	8,540,000.00	8,540,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,881,700,780.88	4,569,304,136.36
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,881,700,780.88	4,569,304,136.36
392	Биет хөрөнгө	4,864,037,780.88	4,547,295,136.36
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,462,620,853.00	1,474,368,562.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(394,313,383.06)	(453,244,944.58)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	199,528,800.00	199,528,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(149,650,590.43)	(168,783,923.51)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	125,501,531.00	131,001,531.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(86,614,159.16)	(99,872,588.80)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	64,171,887.30	64,171,887.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	(39,879,721.66)	(43,907,624.14)
39209	Зам, гүүрийн байгууламж	615,196,054.00	615,196,054.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(75,735,785.78)	(106,052,087.30)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,379,933,711.00	3,431,773,115.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(523,796,179.33)	(783,958,408.61)
39217	Ном	287,074,764.00	287,074,764.00
393	Биет бус хөрөнгө	17,663,000.00	22,009,000.00
39301	Програм хангамж	1,382,700.00	1,382,700.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(757,700.00)	(907,700.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	17,038,000.00	21,534,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,953,259,544.88	4,597,897,330.36

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,953,259,544.88	4,597,897,330.36
51	Засгийн газрын хувь оролцоо	4,953,259,544.88	4,597,897,330.36
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	598,642,048.96	598,642,048.96
51101	Өмч: - төрийн	598,642,048.96	598,642,048.96
512	Хуримтлагдсан үр дүн	3,996,630,103.37	3,641,267,888.85
51210	Өмнөх үеийн үр дүн	3,996,630,103.37	3,996,630,103.37
51220	Тайлант үеийн үр дүн	-	(355,362,214.52)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	357,987,392.55	357,987,392.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,953,259,544.88	4,597,897,330.36

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	714,853,016.90	675,353,956.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	232,627,814.00	70,958,113.00
120	Нийтлэг татварын бус орлого	230,492,814.00	70,958,113.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	230,492,814.00	70,958,113.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	93,000,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	137,492,814.00	70,958,113.00
122	Тусламжийн орлого	2,135,000.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	2,135,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	482,225,202.90	604,395,843.90
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,612,002.90	84,110,543.90
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	17,543,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	17,323,456.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,521,102.90	11,414,999.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,090,900.00	37,829,088.90
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	451,613,200.00	520,285,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	451,613,200.00	520,285,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	929,903,476.20	1,029,641,171.42

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

21	УРСГАЛ ЗАРДАЛ	919,742,226.20	1,004,895,671.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	874,899,311.33	910,822,933.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	254,008,477.07	258,540,157.63
210101	Үндсэн цалин	254,008,477.07	145,205,755.32
210102	Нэмэгдэл	-	60,482,473.86
210105	Гэрээг ажлын хөлс	-	52,851,928.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,201,991.97	33,500,291.84
210201	Тэтгэврийн даатгал	21,911,402.30	23,681,476.71
210202	Тэтгэмжийн даатгал	2,738,493.04	2,635,801.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,031,192.63	2,037,412.49
210204	Ажилгүйдлийн даатгал	501,899.45	495,880.94
210205	Эрүүл мэндийн даатгал	5,019,004.54	4,649,720.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,753,600.00	92,795,614.00
210301	Гэрэл, цахилгаан	26,584,649.00	27,916,147.00
210302	Түлш, халаалт	55,701,107.00	63,576,667.00
210303	Цэвэр, бохир ус	1,467,844.00	1,302,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,376,499.60	28,770,238.90
210401	Бичиг хэрэг	2,849,700.00	2,089,300.00
210402	Тээвэр, шатахуун	17,598,668.60	11,542,826.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,632,500.00	1,328,782.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	12,979,260.10
210408	Бараа материал акталсны зардал	10,295,631.00	830,070.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,445,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,445,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,902,300.00	2,672,000.00
210702	Дотоод албан томилолт	2,902,300.00	2,672,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,554,100.40	2,656,658.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,556,875.40	721,991.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	582,225.00	552,667.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	132,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	452,102,342.29	490,442,973.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,508,450.00	104,359,216.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	104,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	429,593,892.29	385,979,757.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,842,914.87	94,072,737.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,197,500.00	28,719,700.00

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,280,800.00	28,719,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	916,700.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	65,353,037.53
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	65,353,037.53
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,645,414.87	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,645,414.87	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,161,250.00	24,745,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,161,250.00	24,745,500.00
223001	Бусад хөрөнгө	10,161,250.00	24,745,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(215,050,459.30)	(354,287,214.52)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,170,000.00	1,075,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	35,000.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2,135,000.00	1,075,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(2,170,000.00)	(1,075,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(217,220,459.30)	(355,362,214.52)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	598,642,048.96	415,229,648.79	4,141,176,054.42	5,155,047,752.17
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	57,242,256.24	57,242,256.24
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	598,642,048.96	415,229,648.79	4,198,418,310.66	5,212,290,008.41
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайланг үеийн үр дүн	-	-	(217,220,459.30)	(217,220,459.30)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	598,642,048.96	357,987,392.55	3,996,630,103.37	4,953,259,544.88
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	598,642,048.96	357,987,392.55	3,996,630,103.37	4,953,259,544.88
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	598,642,048.96	357,987,392.55	3,996,630,103.37	4,953,259,544.88
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайланг үеийн үр дүн	-	-	(355,362,214.52)	(355,362,214.52)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	598,642,048.96	357,987,392.55	3,641,267,888.85	4,597,897,330.36

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	575,225,202.90	606,436,843.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	93,000,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	93,000,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	93,000,000.00	-
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	93,000,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	482,225,202.90	606,436,843.90
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,612,002.90	86,151,543.90
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	17,543,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнгэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	17,323,456.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,521,102.90	11,414,999.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,090,900.00	39,870,088.90
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	451,613,200.00	520,285,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	451,613,200.00	520,285,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	490,225,202.90	591,818,843.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	490,225,202.90	591,818,843.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	445,382,288.03	497,746,106.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	254,008,482.53	258,540,157.63
210101	Үндсэн цалин	153,213,908.50	145,205,755.32
210102	Нэмэгдэл	51,883,672.52	60,482,473.86
210105	Гэрээт ажлын хөлс	48,910,901.51	52,851,928.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,201,986.50	33,500,291.84
210201	Тэтгэврийн даатгал	23,537,094.24	23,681,476.71
210202	Тэтгэмжийн даатгал	2,245,905.44	2,635,801.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,722,266.91	2,037,412.49
210204	Ажилгүйдлийн даатгал	432,520.59	495,880.94
210205	Эрүүл мэндийн даатгал	4,264,199.32	4,649,720.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,753,600.00	92,795,614.00
210301	Гэрэл, цахилгаан	26,584,649.00	27,916,147.00
210302	Түлш, халаалт	55,701,107.00	63,576,667.00
210303	Цэвэр, бохир ус	1,467,844.00	1,302,800.00

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2104	Хангамж, бараа материалын зардал	21,724,400.00	28,489,550.00
210401	Бичиг хэрэг	3,300,700.00	2,638,300.00
210402	Тээвэр, шатахуун	15,714,200.00	11,542,618.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,709,500.00	1,328,782.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	12,979,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,902,300.00	2,672,000.00
210702	Дотоод албан томилолт	2,902,300.00	2,672,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,553,398.00	2,656,658.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,556,173.00	721,991.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	582,225.00	552,667.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	132,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,238,121.00	77,591,834.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,238,121.00	77,487,834.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	104,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,842,914.87	94,072,737.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,197,500.00	28,719,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,280,800.00	28,719,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	916,700.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	65,353,037.53
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	65,353,037.53
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,645,414.87	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,645,414.87	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	85,000,000.00	14,618,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	85,000,000.00	14,618,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	85,000,000.00	14,618,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	85,000,000.00	14,618,000.00
223001	Бусад хөрөнгө	85,000,000.00	9,118,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	5,500,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(85,000,000.00)	(14,618,000.00)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	520,285,300.00	488,463,362.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	506,167,300.00	479,345,362.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	477,447,600.00	450,625,662.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	264,439,100.00	258,540,157.63
210101	Үндсэн цалин	156,473,300.00	145,205,755.32
210102	Нэмэгдэл	52,084,100.00	60,482,473.86
210105	Гэрээт ажлын хөлс	55,881,700.00	52,851,928.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,190,400.00	33,500,291.84
210201	Тэтгэврийн даатгал	24,612,800.00	23,681,476.71
210202	Тэтгэмжийн даатгал	2,644,400.00	2,635,801.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,115,500.00	2,037,412.49
210204	Ажилгүйдлийн даатгал	528,900.00	495,880.94
210205	Эрүүл мэндийн даатгал	5,288,800.00	4,649,720.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,339,700.00	88,113,796.00
210301	Гэрэл, цахилгаан	26,232,500.00	27,916,147.00
210302	Түлш, халаалт	60,307,200.00	58,894,849.00
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	1,302,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,144,700.00	19,994,700.00
210401	Бичиг хэрэг	2,501,500.00	2,323,300.00
210402	Тээвэр, шатахуун	10,943,200.00	10,842,618.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	1,328,782.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,500,000.00	5,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,514,500.00	2,672,000.00
210702	Дотоод албан томилолт	5,514,500.00	2,672,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,015,000.00	1,934,667.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	600,000.00	552,667.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	132,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,304,200.00	44,370,050.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,304,200.00	44,370,050.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,719,700.00	28,719,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,719,700.00	28,719,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,719,700.00	28,719,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,118,000.00	9,118,000.00
223001	Бусад хөрөнгө	14,118,000.00	9,118,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	520,285,300.00	488,463,362.47
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	472,363,100.00	488,463,362.47
320001	Орон нутгийн төсвөөс	472,363,100.00	488,463,362.47
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	47,922,200.00	0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	47,922,200.00	0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	T3 цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	86,151,543.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	86,151,543.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	52,620,443.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,681,818.00
210302	Түлш, халаалт	4,681,818.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,494,850.00
210401	Бичиг хэрэг	315,000.00
210402	Тээвэр, шатахуун	700,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,479,850.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	721,991.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	721,991.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,721,784.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,617,784.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,531,100.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	33,531,100.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	33,531,100.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	86,151,543.90
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	86,151,543.90
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	17,543,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,738,455.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	39,870,088.90

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлт, худалдан авалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 03/42 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газар нь оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар сумынхаа хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий байгууллага юм.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 05 сарын 09-ны өдрийн А/35 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 663,606.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,954.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7,963.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газрын төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулга хийсэн тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос дахин тооцлоо.

Гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 10,130.3 мянган төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 176.2 мянган төгрөгөөр өссөн байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 8,104.2 мянган төгрөгөөр тогтоогдсон байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Орлого:

Тус байгууллага 2021 онд орон нутгийн төсвөөс 520,285.3 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд 84,110.5 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 70,958.1 мянган төгрөг нийт 675,353.9 мянган төгрөг, өмнөх оноос 39,499.0 мянган төгрөгөөр буюу 5.5 хувиар буурсан байна. Энэ нь үнэ төлбөргүй орлого буурсантай холбоотой байна.

Зардал:

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 1,029,641.1 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 591,818.8 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 488,463.3 мянган төгрөг зарцуулсан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100141455001 тоот дансанд 2021 онд 520,285.3 мянган төгрөгийн орлого, 520,285.3 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100141455408 тоот дансанд 41,374.5 мянган төгрөгийн орлого төвлөрч, 41,374.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мян.төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	41,374.5	1,430.0	-39,944.5
Урьдчилгаа			
Бараа материал	30,184.2	27,163.2	-3,021.0
Үндсэн хөрөнгө	4,881,700.7	4,569,304.1	-312,396.6
Нийт хөрөнгө	4,953,259.5	4,597,897.3	-355,362.2
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,953,259.5	4,597,897.3	-355,362.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,953,259.5	4,597,897.3	-355,362.2

Авлагын дансны үлдэгдэл 1,430.0 мянган төгрөг болж 39,944.5 мянган төгрөгөөр буурсан нь өвс тэжээлийн авлага барагдсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 27,163.2 мянган төгрөг болж 3,021.0 мянган төгрөгөөр буурсан нь бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,569,304.1 мянган төгрөг болж 312,396.6 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 5,500.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 68,083.1 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгө данснаас хасагдаагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,597,897.3 мянган төгрөг болж 355,362.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 501,931.1 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 501,931.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 18,354.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж орон нутгийн төсвөөс 472,363.1 мянган төгрөг, урьд оны шилжих үлдэгдлээс 47,922.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, эд хогшил урсгал засварын зардал, томилолт зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 472,363.1 мянган төгрөгийн төсвийг орон нутгийн төсвөөс, 47,922.2 мянган төгрөгийг урьд оны шилжих үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 520,285.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 488,463.3 мянган төгрөгийг зарцуулж, 31,821.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 488,463.3 мянган төгрөг буюу 93.8 хувь байгаа нь орон тоо дутуу ажилласнаас цалингийн зардлын гүйцэтгэл 94.7 хувь, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн гүйцэтгэл 95.1 хувь, цар тахалтай холбоотойгоор томилолт, зочны зардлын гүйцэтгэл 48.4 хувь, бараа үйлчилгээний бусад зардал 73.5 хувь, хөрөнгийн зардал 64.5 хувийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Оны эхний үлдэгдэл 7,499.2 мянган төгрөг байсан. Тайлант онд Монгол тур ХХК-аас ан амьтны био техникийн зардал 2,000.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргаас ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, малын гоц халдварт өвчний үеийн үйл ажиллагаанд 12,700.0 мянган төгрөг, халаалтын тарифын зөрүү 5,123.5 мянган төгрөг, “Төв Чандмань” ДЭХГазраас Засгийн газраас төлсөн усны үнэ 9,409.6 мянган төгрөг, аймгийн Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогын зардалд 722.0 мянган

төгрөг, сургалтад зориулж 104.0 мянган төгрөг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хамтарсан багийн зардал 500.0 мянган төгрөг, иргэд аж ахуйн нэгжээс “Хоггүй амьдаръя” аяны хандив 7,500.0 мянган төгрөг, Ковидгүй зун аяны хандив 10,043.0 мянган төгрөг, цахим тендерийн хураамж 426.5 мянган төгрөг, өвс тэжээлийн авлага 29,944.4 мянган төгрөг, аймгийн Засаг даргын Тамгын газраас шатахууны зардал 179.4 мянган төгрөг, нийт 86,151.5 мянган төгрөгийн орлого орсон байна.

Үүнээс бичиг хэргийн зардалд 315.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 700.0 мянган төгрөг, хог хаягдал түрж, булах зардалд 7,479.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид 722.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 38,590.0 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 104.0 мянган төгрөг, нийт 46,724.4 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 33,531.1 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газарт онцолсон асуудал байхгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газарт худалдан авалтуудыг э-баримтаар баталгаажуулж байх албан шаардлага өгсөн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл. Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цэсэнд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс хугацаандаа мэдээлсэн 140 мэдээлэл, хугацаа хоцроосон 8 мэдээлэл, мэдээлээгүй 1 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлангийн аудитад шаардлагатай баримт, материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар туслах үйл ажиллагааны төлөвлөлт, худалдан авалтыг и-баримтаар баталгаажуулах, үндсэн хөрөнгийг дахин үнэлэн бүртгэхтэй холбоотой 2 зөвлөмж өгөгдсөн байна. Хэрэгжилтийг 2021 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 03/231 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нэмэлт дансан дахь орлогын талаар дараагийн аудитаар авч үзнэ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 114,771.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 82,600.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,236.3 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 29,934.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага бичив.

4.1 Залруулсан алдаа

Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн хөрөнгө худалдан авсан 5,500.0 мянган төгрөгийн зардлыг хөрөнгийн зардлаар тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Төсвийн зарцуулаагүй үлдэгдэл болох 65,353.0 мянган төгрөгийг төвлөрүүлснийг буруу кодоор тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн

санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Нийт 11,747.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.3 Албан шаардлага

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулгын дүнг/ Татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд Е баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 24,897.5 мянган төгрөгөөр дутуу, 5,037.1 мянган төгрөгөөр илүү байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.” Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар”-ын 6.5-д Төлбөрийн баримт “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”, санхүүгийн тайлангийн аудитын “Иж бүрэн байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1 “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нийцлийн аудиттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цэсэнд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс хугацаандаа мэдээлсэн 140 мэдээлэл, хугацаа хоцроосон 8 мэдээлэл, мэдээлээгүй 1 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

- Шилэн дансанд байршуулбал зохих мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд, тухай бүр мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа. зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Лүн ЗДТГ	6	114,771.8	3	82,600.7	0	0	1	29,934.7	1	2,236.3